

Монголчуудаас манжийн төрд залгуулж байсан олон төрлийн алба үүргийг дараах хэдэн зүйлд хуваан үзэж болно. Үүнд:

- Манжийн хаанд залгуулах алба (Есөн цагаан буюу шинэлэхийн жасаа, Түнлий номын жасаа, ангийн үс, махны алба, хааны сүрэг хариулах)
- Манжийн засаг захиргааны алба (аймаг, хошуу, шавийн тамгын газруудтай холбогдсон алба, уул тайх г.м.)
- Цэргийн алба
- Чин улсын орон нутгийн өртөө, харуулын алба
- Хятадын худалдаа мөнгө хүүлэгчдэд төлөх албаны өр зэрэг алба үүргээс бүрдэж байжээ.

Манжийн эрхшээлийн үеийн монголчуудын залгуулж байсан хүнд хүчир албаны нэг нь харуулын алба юм. Манж Чин улс монголчуудыг эрхшээлдээ оруулснаас хойш Монгол газар нутагт гэр харуул, суман харуул, дотуур харуул, алтны харуул зэргийг байгуулсан бөгөөд тэдгээр нь гүйцэтгэх үүрэг, зохион байгуулалтын хувьд ялгаатай, өөр өөрийн онцлог бүхий байв.

- Гэр харуулын албанд монголчууд гэр бүлийн хамт хилийн зүг нүүж, 10 жилийн хугацаатайгаар цэргийн албаны журмаар суулгадаг.

Манжийн үеийн монголчуудын эр бие, өрхөөр хаах нэгэн хүнд хүчир алба бол өртөө юм. Өртөө нь Манж Чин улсын төвлөн сууж байсан Бээжин хотыг Өвөр, Ар Монгол, Шинэ хязгаар зэрэг Монголчууд нутаглан суусан гол зангилаа газруудтай холбох үүрэгтэй байв.

Худалдаа, мөнгө хүүлэл

Манжийн эрхшээлийн үед Монгол нутагт монгол худалдаачдаас гадна хятадын мөнгө хүүлэгч худалдаа, орос болон бусад орны худалдаа арилжаа хөгжиж байжээ. Манжийн эрхшээлийн үед Монголын худалдаа зарим талаар хөгжиж, ахиц дэвшил гарсан хэдий ч монголын зах зээл бүхэлдээ гадаадын худалдаачдын гарт орж, худалдаачид эдийн засгийн хувьд тэдний хараат байдалтай байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Хятадын худалдаачид эд бараа, мөнгийг монголчуудад жилд 36 хувийн хүүтэйгээр зээлүүлээд, 3 жилийн дотор өрийг төлж дуусгах шаардлага тавьдаг байв. Гэвч Монголчууд өрөө хугацаанд нь төлж чаддаггүй тул түүнийг далимдуулан төлөх хугацааг дахин 3 жилээр сунгаж, хүүг үржүүлдэг байжээ.

Манжийн 9 эрүү

Манжийн төр монголчуудыг гэсгээн цээрлүүлэх, ял шийтгэл оноохдоо хэрэгтнийг шаахайдах, мүглэнд хийх, талхидах, савслага, хонгор азарга, хулс шаах, төөнөх, банздах, туйпуу сугалах гэсэн 9 эрүүг хэрэглэдэг байжээ.

МАНЖИЙН ҮЕИЙН ЭРҮҮ ШҮҮЛТ



ШЛАХАЙДАХ



МҮГЛЭН



ТАЛХИДАХ



САВСЛАГА



ХОНГОР АЗАРГА



ХҮЛС ШААХ



ТӨӨНӨХ



БАНЭДАХ



ТҮЙПҮҮ СУЛАХ